



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/158

Улаанбаатар хот

Газрын зөрчил арилгахад шаардагдах
зардал гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20, Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3, 57.4 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн 1-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, талбайд зөвшөөрөлгүй байршуулсан түргэн үйлчилгээний цэгийг албадан нүүлгэх, нийтийн эзэмшлийн газарт зөвшөөрөлгүй барьсан өргөтгөлийн барилга, хашаа, хайлсыг буулгах, газар чөлөөлөх ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Нийтийн эзэмшлийн гудамж, талбай чөлөөлөх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (М.Навчаа), Газар зохион байгуулалтын алба (Ж.Тамир)-д тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т зөвшөөрсүгэй.

4.Төсвийн зарцуулалтад хяналт тавьж, гүйцэтгэлээр санхүүжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Менежер (Л.Цэеэрэгзэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ



1525010537